

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2014 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ

Нэг.Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны талаар:

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид 11 дүгээр сард 2 удаа хуралдаж 20 асуудал хэлэлцэн, 20 тогтоол баталлаа.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид Түшиг сумын нутагт үйл ажиллагаа явуулж буй “Улаан Овоо”-ийн нүүрсний уурхайн үйл ажиллагаатай танилцаж, уурхайн ойрын болон хэтийн зорилт, цаашид авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар тус уурхайн удирдлагуудтай санал солилцлоо.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нийгмийн бодлогын хороо “Сургалтын чанар” хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хяналт, шинжилгээ үнэлгээ хийх зорилгоор Мандал сумын төрийн өмчит 12 жилийн 2, 3-р сургууль хувийн хэвшлийн “Билиг дб” зэрэг сургуулиуд дээр ажиллалаа.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Байгаль орчин, үйлдвэр хөдөө аж ахуйн бодлогын хороо “Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрийг эрчимжсэн мал аж ахуй, газар тариалангийн бүс нутаг болгох тухай”, “Малчид тариаланчдын үйл ажиллагааны зохицлыг хангах журам”-ын тухай зэрэг тогтоолуудын хэрэгжилтийг шалгах зорилгоор Хушаат, Орхон, Баруунбүрэн сумдад ажиллалаа.

Олон жил ашиглагдаж элэгдлээ нөхсөн, цаашид албан ажилд ашиглах боломжгүй, ашиглалтгүй байгаа зарим байгууллагуудын тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил, автомашин, барилга байгууламжуудыг орон нутгийн өмчийн албаны санал дүгнэлтийн дагуу акталж, дуудлага худалдаагаар худалдахыг зөвшөөрч доод үнийг баталлаа.

Орхон сумын нутагт үйл ажиллагаа явуулж буй Христийн шашны “Орхон ариун гэрэл” баптист сүмийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийн хугацааг 2 жилийн хугацаагаар сунгалаа.

Мандал сумын Түнхэл тосгон үүсгэн байгуулагдсаны Түүхт 50 жилийн ой тохиож байгаатай холбогдуулан ирэх 2015 оны 07 дугаар сард тэмдэглэн өнгөрүүлэхийг зөвшөөрлөө.

Монгол Улсын Их Хурал, Швейцарын Хөгжлийн агентлаг, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс хамтран хэрэгжүүлж буй “Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхийг бэхжүүлэх нь” төслийн 3 дахь үе шатыг хэрэгжүүлж, “Цахим хуудас”-ны талаарх сургалтыг сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга, ажилтнуудад зохион байгууллаа.

2. Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаар:

Аймгийн Засаг даргын тамгын газар, Үйлдвэр хөдөө аж ахуйн газар хамтран аймгийн хэмжээнд нийтийн хоолны үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн дунд ажил мэргэжлийн аварга шалгаруулах тэмцээн, “Аймгийн аварга тогооч шалгаруулах уралдаан”-ыг зохион байгуулж, 1-р байранд Сүхбаатар сумын “Сэлэнгэ ресторан”-ы тогооч Э.Сумъяа, 2-р байранд Сүхбаатар сумын “ИХО ресторан”-ы тогооч Б.Батбаатар, 3-р байранд Сүхбаатар сумын “Монголжин” зоогийн газрын тогооч н.Энх-Амар, 4-р байранд Сүхбаатар сумын “Монгол зоог” зоогийн газрын тогооч н.Энхцэцэг нар шалгарлаа. Тэмцээний үеэр “Хоол үйлдвэрлэл эрхлэгчдэд тавигдах шардлага” сэдвээр Сүхбаатар сумын мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвөөс сургалт зохион байгууллаа.

“Иргэдээ сонсьё” телевизийн шууд нэвтрүүлэгт Аймгийн Музей, Нийтийн номын сан, Соёл, спорт аялал жуулчлалын газар, Сэлэнгийн долгио чуулга, Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтэс, Үйлдвэр, хөдөө аж ахуйн газар, Татварын хэлтэс, Тээвэр авто замын газруудыг оролцуулан, иргэдээс тус байгууллагуудад ирүүлсэн санал, хүсэлтийн шийдвэрлэлтэнд хяналт тавин ажиллаж байна.

Улс тунхагласны 90 жилийн ойн өдөр төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлөөс төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргүүлэх ёслолын арга хэмжээг зохион байгуулж, аймгийн Засаг даргын Тамгын газрын 4, Үйлдвэр, хөдөө аж ахуйн газрын 2, Хөдөлмөрийн хэлтсийн 6, Нийгмийн халамж үйлчилгээний хэлтсийн 7, Нийгмийн даатгалын хэлтсийн 5, Худалдан авах ажиллагааны албаны 2, Шүүхийн тамгын газраас 4, Сүхбаатар сумын Засаг даргын Тамгын газраас 5 нийтдээ 35 төрийн албан хаагч тангараг өргөлөө.

Аймгийн Засаг даргаас иргэнрүү хандсан бодит ажил арга хэмжээнүүдийг зохион байгуулж байна. Үүний нэг нь хүүхэд, эцэг эх, сургуулиас гаргасан санаачилгыг бодит үр дүнд хүргэхийг зорьж, аймгийн Засаг дарга Сүхбаатар сумын Г.Бумцэндийн нэрэмжит ерөнхий боловсролын 1-р суруулийн удирдлагууд, эцэг эхчүүдтэй уулзалт зохион байгууллаа. Сүхбаатар сумын 4-р багийн хүүхдүүдийг өглөө эрт автобусанд суугаад хичээлдээ ирдэг болгох зорилгоор 2014 онд аймгийн төв байрлах Салхитын амыг тойруулж зам тавьснаар нийтийн тээвэр, таксины үйлчилгээг тус газарт амьдарч буй иргэд авах болсон нь иргэдийн сэтгэлд нийцсэн томоохон ажил боллоо.

Хэнтий аймгийн Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлөөс 2014 оны 11 сарын 27-ны өдөр 2013 оны ажлаараа улсад тэргүүлсэн Сэлэнгэ аймгийн Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн үйл ажиллагаатай танилцаж, туршлага судлах арга хэмжээг зохион байгууллаа.

Àèí æéí Çàñàà ààðàà Ñ.Á¿ðýí ààò òýðä¿¿òýé àæùí òýñýá Í ÕÓ-ùí Áóðèàà òèñùí ò° ðèéí òýðä¿¿í èé òðèèääàð 2014 оны 11 ñàðùí 19-21-í èé ° äð¿¿äýá àèàáí àèé-èàè òèééýý. Тус айлчлалаар

- Nyéyí äý àèí àà Áóðèàà òèñùí çàð çýýèä æèä äóí äæààð 10.0 ì ýí ää ì ð-èì òí ì àò, 1.0 ñàý ì ð-èì òí í ¿¿ðñí èéé¿¿èýò áí èí ì æийг судлах
- Сэлэнгэ аймаг, БНХАУ-ын Өа° ð ì ì í ä è, Бóðèàà äòäáí òèñùí òàì òàðñàí àýèàè æóòè-èàèùí á¿ñí òòæéä° äæ¿¿èýò
- Уламжлалт “Эв мод”-í ù í àààì ù äá¿ñí òòæéí ýàèéí çàñæéä° äæ¿¿èæ ° ðòèéí ì ðèí äü ä í ýí ýæ¿¿èýò ì èíí òèñùí ýèñí ì ýàðì àä áí èä æ ° ðä òä ò
- Еð° í òèé áí èí àñðí èùí ñòðäóòèèòáàä Õðí ñ, Мí í ä è áàäæ í àðù ä òàðèèòáí ñí èèèòí ò
- Ерөнхий боловсролын сургуулиа àì æèèòàè ñàéí ò° äññ° í 3-5 ò¿¿òäèèääð° í òèéè° ä-èéí èáýýè äí ð Áóðèàà òèñàä Nyéyí äý àèí àä ì ýí òýðýäýýòýé áàèèäà ì ýðäýæýýð ñòðääò
- Аõí àä í àñòàí , ò¿¿òýä áàää-óóäù äàì àð-, ñóàèèóóèäò
- Хилээр нэвтрэн гарч буй Монгол иргэдэд тулгарч буй асуудлыг шийдвэрлэх талаар ðэлэлцэн, санал солилцож, хамтран àæèèàðààð áí èèí ì.

Аймгийн Засаг даргын Тамгын газар, Хаан банк, Lady сургалын төвтэй хамтран аймгийн Засаг даргын Тамгын газар, Хаан банкны ажилтан албан хаагчдад “Хувь хүнийг хөгжүүлэх нь” сэдэвт сургалтыг зохион байгууллаа.

Тайлант сард аймгийн Засаг даргын Тамгын газрын 70361111 утсанд нийт 14 иргэн санал, хүсэлт гаргаснаас 10 асуудлыг шийдвэрлэж, 4 асуудал шийдвэрлэх шатандаа байна. Иргэдээс аймгийн Засаг даргын Тамгын газарт нийт 23 өргөдөл ирснээс 8 өргөдлийг шийдвэрлэж, 15 өргөдөл шийдвэрлэх шатандаа явж байна.

Бусад ажлын талаар:

1.Онцгой байдлын газар:

Аймгийн Онцгой байдлын газраас Баруунбүрэн суманд гамшгаас хамгаалах команд штабын иж бүрэн сургууль зохион байгууллаа.

Аймгийн Онцгой байдлын газар, НҮБ-ын орон нутгийн чадавхийг бэхжүүлэх төсөл, Дэлхийн зөн олон улсын байгууллагатай хамтран Сэлэнгэ аймгийн Мандал

сумын ерөнхий боловсролын сургууль, Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн сурагчид, ард иргэдийн дунд сургалт, эрсдэлгүй орчин дэвжээ тэмцээнийг зохион байгууллаа.

ОХУ-ын Буриад Улсын Хиагт хотын Онцгой байдал, гал унтраах ангийн удирдлага, бүрэлдэхүүнийг аймгийн Онцгой байдлын газрын үйл ажиллагаатай танилцуулж, харилцан мэдээлэл солилцох, туршлага судлах ажлыг зохион байгууллаа.

2.Стандартчилал хэмжил зүйн хэлтэс:

Тайлант сард аймгийн Стандартчилал хэмжил зүйн хэлтсээс “Стандарт-Ижил тэгш өрсөлдөх боломжийг бий болгож байна” аяныг зарлаж, Цагааннуур сумын худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийн дунд "Стандарт-худалдаа үйлчилгээнд" сэдэвт ажил мэрэгжлийн тэмцээн зохион байгууллаа.

Аймгийн Стандартчилал хэмжил зүйн хэлтсээс Сүхбаатар суманд үйл ажиллагаа явуулж буй төрийн болон төрийн бус байгууллагын бичиг хэргийн ажилтнуудад “Зохион байгуулалт, захирамжлалын баримт бичгийн стандарт MNS 5140:2011” цуврал стандартаар сургалт зохион байгууллаа.

Мандал, Сайхан, Цагааннуур, Түшиг, Баянгол, Сүхбаатар сумдад ээлжит баталгаажуулалтыг хийж, худалдаа үйлчилгээний 42 газруудад тохирлын үнэлгээ хийн, сумын баталгаажуулалтын орон тооны бус салбар зөвлөлийн хурлыг хуралдуулж, худалдаа, үйлчилгээний газрын мөрдвөл зохих стандартын 84.0-өөс дээш хувийг хангасан 32 худалдаа, үйлчилгээний газарт тохирлын гэрчилгээ олголоо.

Зүүнбүрэн сумын аж ахуйн нэгж, иргэний бүтээгдэхүүнүүдийг сайн дурын баталгаажуулалтанд хамруулж, итгэмжлэгдсэн лабораторийн сорилт, шинжилгээний дүнг үндэслэн шинжээчийн дүгнэлт гаргалаа.

Стандартын салбар сангаас 6 аж ахуйн нэгж, иргэний хүсэлтийн дагуу 5 нэрийн 6 стандартаар хангаж, арга зүйн зөвөлгөө өгч, 5 нэр төрлийн 5 стандартаар үйлчилгээ үзүүллээ.

Сүхбаатар, Шаамар, Цагааннуур, Түшиг сумын худалдаа үйлчилгээнд ашиглаж байгаа 39 жин, “ЦШ” ХХК-ийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа 11 дамжлагын жинг баталгаажууллаа.

Айл өрх, аж, ахуй нэгж, байгууллагын төлбөрийн тооцоонд ашиглагдаж байгаа 1 фазын 35 ш цахилгааны тоолуурыг баталгаажуулалтанд хамрууллаа.

Хоёр.Эдийн засаг, санхүүгийн бодлогын хүрээнд:

1.Төсвийн гүйцэтгэлийн талаар:

10-р сарын 31-ний байдлаар		/мянган төгрөгөөр/		
Д/д	Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
1	Орон нутгийн төсвийн нийт орлого	1295426.7	12012393.1	92.8
	Үүнээс: Аймгийн төсвийн орлого	10593623.2	9614192.4	90.8
2	Орон нутгийн төсвийн нийт зарлага	61876692.60	52882067.20	85.5
	Үүнээс: Аймгийн төсвийн зарлагын дүн	17640296.0	13673584.0	77.5
	- Аймгийн ОНХСангийн зарцуулалт	4013570.70	2184048.30	54.4
3	Улсын төсвөөс олгосон ОНХСангийн орлогын шилжүүлэг	9865809.60	5798006.0	58.8
4	Улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг	3322276.70	3322276.70	100.0
5	Сумдад олгосон санхүүгийн дэмжлэг	5408712.10	5437548.30	100.5

7	Засаг даргын нөөц	507600.0	427644.60	84.2
---	-------------------	----------	-----------	------

2014 оны төсвийн гүйцэтгэлийн 10 сарын мэдээгээр орон нутгийн төсвийн орлого 92.8 хувь, улсаас авах санхүүгийн дэмжлэг 100.0 хувь, орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг 58.8 хувь, салбарын байгууллагуудын тусгай зориулалтын шилжүүлэг 100.0 хувь тус тус биелэгдсэн байна. Төсвийн зарлагын гүйцэтгэл 85.5 хувийн биелэлттэй байна. Аймгаас олгох сумдын санхүүгийн дэмжлэг 100 хувь, Засаг даргаас олгох нөөц хөрөнгийн гүйцэтгэл 84.2 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

2.Өргөн хэрэглээний барааны үнэ ханшийн тухай:

№	Барааны нэр, төрөл	Хэмжих нэгж	Үнэ, ханш /төгрөгөөр/	
			2013 оны 10-р сар	2014 оны 11-р сар
Нэг.Талх, гурил, будаа				
1	Гурил /1-гурил/	1 кг	1200	1100-1200
2	Талх /орон нутгийн/ том, жижиг	ш	1000, 2200	1000, 2200
3	Нарийн боов	1 кг	1900-2500	1900-2500
4	Элсэн чихэр	1 кг	1800-2100	1800-2100
5	Цагаан будаа	1 кг	2200-2400	
Хоёр.Мах, махан бүтээгдэхүүн				
6	Хонины мах	1 кг	6500	6500
7	Үхрийн мах	1 кг	7500	7000
8	Адууны мах	1 кг	6000	6000
9	Ямааны мах	1 кг	5800	5800
10	Дотор мах цувдай	1 кг	4000	4000
11	Хиам, чанасан	1 кг	9000	9000
12	Гахайн мах	1кг	6000	6500
Гурав.Сүүн бүтээгдэхүүн				
12	Сүү /задгай/	1л	800	1000
13	Сүү /савласан/	1л	2500	2500
14	Тараг /задгай/	1л	1000	1100
15	Хорхой ааруул	1 кг	10000	10000
16	Айраг	1л	-	-
17	Хуурай сүү /орос/	1 кг	4000	4000
18	Өндөг	ш	350	330
Дөрөв. Бүх төрлийн өөх тос				
19	Ургамлын тос	1 кг	2900-3300	2900-3300
20	Өөхөн тос	1 кг	1500	1500
21	Шар тос	1 кг	8000	8000
22	Масло /задгай/	1 кг	3200	3200
Тав.Хүнсний ногоо				
23	Төмс	1 кг	800	800
24	Лууван	1 кг	1000	800
25	Манжин	1 кг	800	800
26	Байцаа	1 кг	800	700
27	Сонгино	1 кг	1000-1500	1000-1500
28	Өргөст хэмх	1 кг	-	-
29	Тарвас /Монгол/	1 кг	-	-
30	Өргөст /даршилсан/ хэмх	ш	3500	3500

31	Алаг салат /даршилсан/	ш	1900-2500	1900-2500
Зургаа.Тээвэр шатахуун				
32	Бензин А-80	1 л	1590	1590
33	Бензин А-92	1 л	1690	1690
34	Дизель түлш	1 л	1830	1830

Гурав.Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:

1. Архивын талаар:

Архивын ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газраас Сэлэнгэ аймагт хэрэгжүүлж байгаа архивын болон эд хөрөнгийн бүртгэлийн цахимжуулалтын ажлын явцтай танилцах, хяналт шалгалт хийлээ.

Төрийн архивын сан хөмрөгийг нөхөн бүрдүүлэх зорилгоор “Шим” ХХК-ийн 1990-1999 оны /17 хадгаламжийн нэгж/ тушаал болон цалингийн цэс, “Мон ор” ХХК-ийн гүйцэтгэсэн Мандал сумын “Спирт бал бурам” ХХК-ийн ажилчдын 40 айлын орон сууцны барилгын зураг төсөл, техникийн баримт бичгийг хүлээн авлаа.

Худалдаа бэлтгэлийн удирдах газрын хөмрөгийн 1981-1983 оны 21 хадгаламжийн нэгжид нягтлан шалгалтын ажлыг хийж, 14 хадгаламжийн нэгжид сэлбэн засалтын ажлыг хийж гүйцэтгэлээ. Мөн хөмрөгийн 1952-1977 оны 174 хадгаламжийн нэгжийг шинэчилсэн дансны бүртгэлд шивж, хөмрөгт байршууллаа.

Төрийн архивын АМС программд Зүүнбүрэн, Алтанбулаг, Ерөө сангийн аж ахуйн хөмрөгийн 29 хадгаламжийн нэгжийн 4111 хуудасны мэдээллийн агуулгыг уншиж, 11823 заалт, 16779 хүний нэр, 948 байгууллагын нэр, 2414 газар зүйн нэрийг шивж орууллаа. Мөн дээрх хөмрөгүүдийн 25 хадгаламжийн нэгжийн 4588 хуудсыг серверт задалж холболт хийлээ.

Мастер хувиас ашиглалтын хувь үүсгэх ажлын хүрээнд Photoshop програм ашиглан аймгийн Холбооны газрын 18 хадгаламжийн нэгжийн 2087 хуудсаар ашиглалтын хувь үүсгэлээ.

Иргэд, албан байгууллагын хүсэлтийн дагуу архивын хуулбар 84, тодорхойлолт 17, магадлагаа 23, цалингийн тодорхойлолт 3 гаргаж үйлчиллээ.

Дөрөв.Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд:

1. Эрүүл мэндийн талаар:

Аймгийн Эрүүл мэндийн газраас аймгийн 14 сум, 6 тосгоны эмнэлэг, 7 өрхийн эрүүл мэндийн төвд “Эрүүл мэндийн довтолгоо, 21 дадал”-ыг хэвшүүлэх талаар зохион байгуулан хэрэгжүүлж буй ажилд хяналт, үнэлгээ хийлээ.

“Эрүүл мэндийн довтолгоо” арга хэмжээний хүрээнд өрх бүрт заавал хэвшүүлэх 21 дадлыг сурталчлан хэрэгжүүлэх, 9 сарыг “Оюутны эрүүл мэндийг дэмжих сар” болгон зарласантай холбогдуулан өсвөр үеийн оюутан залуусыг эрүүл мэндийн үзлэгт бүрэн хамруулах, эрүүлжүүлэх, мөн тэдний эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлэх, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, идэвхи, санаачилгыг өрнүүлэх зорилгоор аймгийн Эрүүл мэндийн газар, төрийн болон төрийн бус байгууллага, Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв хамтран оюутнуудад сургалт хийж, багш, ажилчид, оюутнуудыг эрүүл мэндийн үзлэгт хамрууллаа. Тус арга хэмжээний хүрээнд аймгийн 3 Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн нийт 526 оюутныг эрүүл мэндийн үзлэгт хамрууллаа.

2014 оныг Эрүүл мэндийн яамнаас “Эх, хүүхдийн эрүүл мэндийг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан 5 хүртэлх насны хүүхдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлж, томуу томуу төст өвчний хүндрэл, нас баралтаас сэргийлж, хяналтыг сайжруулах зорилгоор аймгийн Эрүүл мэндийн газраас 2014 оны 11 сарын 07-ны өдөр “Хүүхдэд үзүүлэх

тусламж, үйлчилгээ, хяналтын асуудал” сэдвээр Алтанбулаг сумын эрүүл мэндийн төв, Сүхбаатар сумын өрхийн эрүүл мэндийн төвийн дарга, их эмч, сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүдийг хамруулан уулзалт, ярилцлага зохион байгууллаа.

Ахмад настны эрүүл мэндийг дэмжих сарыг “Хэнийг ч бүү орхигдуул, хүн бүрт зориулсан нийгмийг дэмжье” уриан дор тэмдэглэн өнгөрүүлж, аймгийн нийт сум, тосгодод ахмад настны эрүүл мэндийг дэмжих сарын ажлын нээлтийн үйл ажиллагаа, өдөрлөгийг сумдын Засаг даргын Тамгын газар, ахмадын хороотой хамтран зохион байгууллаа.

2. Хүүхэд залуучуудын талаар:

Аймгийн Эрүүл мэндийн газар, Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтэс, Дэлхийн Зөн олон улсын байгууллага хамтран “Шүд эрүүл бол бие эрүүл” арга хэмжээг 2014 оны 11 сарын 06-07-ны өдрүүдэд зохион байгуулж, Сүхбаатар сумын I, II цэцэрлэгийн нийт 181 хүүхдэд амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэгийг хийж, шаардлагатай хүүхдүүдэд цоорол зогсоох түрхлэг түрхэж, мөн эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг хийлээ.

НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцийн 25 жилийн ой, “Хүүхэд хамгааллын дэлхийн өдөр”-ийг төрийн болон төрийн бус байгууллагууд хамтран хүүхдэд ээлтэй бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлэх арга хэлбэрээр зохион байгууллаа.

“Миний гэр бүл” хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг 2014 оны 09 сарын 25-аас 11 сарын 03-ны өдрийг хүртэл амжилттай зохион байгууллаа. Тус хөтөлбөрийн хүрээнд аймгийн Боловсролын газар, Эрүүл мэндийн газар, “ХААН”, “Хас”, “Төрийн банк”, “Голомт”-банк хамтран ажиллаж “Шилдэг гэр бүл”-ийг шалгаруулан, урамшууллаа.

3. Нийгмийн халамжийн үйлчилгээний талаар:

Нийгмийн халамжийн тэтгэвэрт 3047 иргэнд 2490020.1 мянган төгрөг, нийгмийн халамжийн нөхцөлт мөнгөн тэтгэмжинд 1349 иргэнд 832035.8 мянган төгрөг, ахмад настанд үзүүлэх хөнгөлөлт тусламжинд 3202 иргэнд 228628.6 мянган төгрөгийг тус тус олголоо.

Амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тусламжинд 1010 иргэнд 397009.9 мянган төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй 625 иргэнд 135477.7 мянган төгрөгийн тусламж хөнгөлөлт үйлчилгээг үзүүллээ.

Эхийн алдар одонтой 8541 эхэд 1168940.0 мянган төгрөгийн тусламж, жирэмсэн, хөхүүл нярай хүүхэдтэй 2982 эхэд 1227348.7 мянган төгрөг, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд 762 иргэнд 72692.9 мянган төгрөг, алдар цолтой ахмадуудад үзүүлэх хөнгөлөлт тусламжийн үйлчилгээнд 88 иргэнд 84910.0 мянган төгрөгийг тус тус олголоо.

4. Боловсролын талаар:

БШУ-ы сайдын 2013 оны А/305 тоот тушаалаар батлагдсан “Багшлах эрх, мэргэжлийн зэрэг олгох, хасах” журмын дагуу Боловсролын газраас багш мэргэжлээр их, дээд сургууль төгссөн 79 хүнээс шалгалт авснаас 30 хүн шалгалтанд тэнцэж, багшаар ажиллах эрх авах боломжтой болоод байна.

2014 оны шилдэг илтгэл хэлэлцүүлэх эрдэм шинжилгээний бага хурал, шилдэг илтгэл шалгаруулах уралдааныг “Хичээлийн төлөвлөлт ба хүүхдийн хөгжил” сэдвээр 2014 оны 11 дүгээр сарын 25-нд аймгийн Боловсролын газар зохион байгууллаа.

2014-2015 оны шинэ хичээлийн жилийн эхлэл байдалтай танилцаж, зөвлөн туслах зорилгоор аймгийн Боловсролын газраас 2014 оны 11 сарын 13-14-ний өдрүүдэд Шаамар, Алтанбулаг сумдын ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт зөвлөн туслах багийг ажилууллаа.

Боловсролын үйлчилгээний сэтгэл ханамж, чанарын шинэчлэлийг хэрэгжүүлэх ажлын явц, үр дүн, тулгамдаж байгаа асуудлыг илрүүлэх зорилгоор аймгийн Боловсролын газраас 60 гаруй багш, 90 гаруй сурагч, 60 гаруй эцэг эхчүүдээс санал асуулга авлаа.

5. Хөдөлмөр эрхлэлтийн талаар:

2014 оны 10-р сарын байдлаар бүртгэлтэй ажилгүй иргэд 852 хүн байсан бол 371 иргэн шинээр бүртгүүлж, ажил олгогчоос ирүүлсэн 258 ажлын байранд 250 хүнийг ажилд зуучилж, идэвхигүйн улмаас 218 иргэн хасагдаж бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 755 боллоо.

Сүхбаатар, Алтанбулаг, Орхон, Хушаат, Сант, Зүүнбүрэн, Түшиг сум, Түнхэл, Хэрх, Дулаанхаан тосгодод 11 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн ойн цэвэрлэгээний ажлыг эхлүүлэн цалин хөлсийг олгож байна.

Аймгийн Хөдөлмөрийн хэлтсээс Алтанбулаг, Шаамар, Мандал сумдын хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдийн ажлын гүйцэтгэлийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн, хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгах талаар зөвлөн туслах үйлчилгээг үзүүллээ.

Аймгийн Хөдөлмөрийн хэлтсээс Баянгол, Мандал, Сант, Сайхан, Хүдэр сумдын сум хөгжүүлэх сангаас зээл авч хугацаа хэтэрсэн аж ахуй нэгж, иргэдийн материалыг бүрдүүлэн шүүхэд өгөх арга хэмжээ авч ажиллалаа.

Хөдөлмөр нийгмийн 3 талт салбар хорооноос Мандал, Ерөө, Сайхан, Цагааннуур, Сүхбаатар сумдад “Сум орон нутгийн нийгмийн түншлэлийн 3 талт салбар хорооны гишүүдийг чадавхижуулах” бүсчилсэн сургалтыг 11 дүгээр сарын 10-19-ны хороонд зохион байгууллаа.

Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 1, 2-р сургуулийн 11, 12 ангийн нийт 100 гаруй сурагчдад “Мэргэжил бүхэн сайхан” сургалтыг зохион байгууллаа.

6. Нийгмийн даатгалын үйлчилгээний талаар:

2014 оны 11 сарын 01-ний байдлаар аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нь Нийгмийн даатгалын сангуудад 19.6 тэрбум төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл оруулах төлөвлөгөөтэйгээс 18.9 тэр бум төгрөг хуримтлуулж, төлөвлөгөөний биелэлт 96.0 хувьтай байна.

Тэтгэврийн даатгалын сангаас 13724 тэтгэвэр авагчдад 32.0 тэр бум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын сангаас 5353 даатгуулагчдад 1.6 тэр бум төгрөгийн хөдөлмөрийн чадвар түр алдалт, жирэмсэн болон амаржсаны, оршуулгын тэтгэмжүүдийг олголоо.

Эрүүл мэндийн даатгалын сангаас 9 эмнэлэг 35 эмийн сангаар үйлчлүүлсэн нийт 65810 иргэний эмчилгээ, эмийн үнийн хөнгөлөлтөнд 2.6 тэрбум төгрөгийг зарцууллаа.

Ажилгүйдлийн даатгалын сангаас 368 даатгуулагчдад 374.5 сая төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж олголоо.

2014 онд 79 ажил олгогч шинээр бүртгэж, 159 даатгуулагчийг албан журмын даатгуулд хамрууллаа.

Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд нийт 19703 иргэний матриалыг хүлээн авч 1990-2000 онуудад ажилгүй байсан хугацааг нөхөн тооцож бүртгэлээ. Мөн 1991-1994 онуудад нөхөн олговроор тэтгэвэрт гарсан 1518 тэтгэвэр авагчийн хүсэлтийг хүлээн авч ажилгүй байсан хугацааг нөхөн тооцлоо.

Тав.Үйлдвэр, хөдөө аж, ахуйн бодлогын хүрээнд:

Энэ жил манай аймгийн тариаланчид нийт 174167 га талбайд тариалалт хийж 127.1 мянган га талбайд чанартай уринш бэлтгэн эргэлтийн талбайгаа 98.6 хувьтай ашиглалтанд орууллаа. Энэ намар 142096 га талбайгаас 242929.1 тонн үр тариа га-аас 17.1 центнер, 28637 га талбайгаас 20795 тонн тосны ургамал га-аас

Аймгийн Прокурорын барилга, Сүхбаатар сумын Спорт сургуулийн спорт заалны барилга дээр улсын комисс ажиллан үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд хүлээн авлаа.

Сайхан сумын төвд шинээр баригдсан “ХААН банк”-ны бизнес зээлийн төвийн барилгыг улсын комиссоор байнгын ашиглалтанд авлаа.

Сайхан суманд хийгдсэн Дөнбөн хорооллын цахилгаан хангамжийн ажил дуусч байнгын ашиглалтанд хүлээлцүүлээ.

“Юнителком” ХХК-ийн гүйцэтгэсэн /Орхон, Баруунбүрэн, Сант, Орхонтуул/ сумдын ажил дуусч байнгын ашиглалтанд хүлээлцүүлээ.

Аймгийн төв Сүхбаатар суманд “Сэлэнгэ АЗЗА” ТӨХК-ийн гүйцэтгэсэн Салхит 3-р багт тойрог зам барих ажил, нийтийн эзэмшлийн талбайд авто зогсоол барих ажил дуусч байнгын ашиглалтанд орууллаа.

“Голомт констракшн” ХХК-ийн гүйцэтгэсэн Орхонтуул сумын шар усны гол дээр гүүр тавих ажил дуусч ашиглалтанд хүлээлцүүлээ.

Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газраас улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр Орхон, Орхонтуул, Сант, Сайхан, Баянгол, Мандал сумдад хийгдэж буй төсөл арга хэмжээнүүдэд захиалагчийн болон хөндлөнгийн хяналт хийлээ.

Долоо. Байгаль орчны чиглэлээр:

Тус аймагт 2014 оноос өмнө хийгдсэн ус хангамжийн эх үүсвэрийн хайгуул судалгааны ажлын талаарх мэдээлэл болон хөв-цөөрөм, хашиж хамгаалагдсан булаг, шандын тайланг Байгаль орчин, ногоон хөгжлийн яаманд хүргүүлээ.

Аймгийн ус ашигласны төлбөрийн орлого тасарч байгаатай холбогдуулан томоохон ус ашиглагч болох “Рэдхил Монголия” ХХК-ийн төлөөлөлтэй уулзаж усны төлбөрийн орлогыг бүрдүүлэх талаар уулзалт зохион байгууллаа.

Тус аймагт мод, модон материалын зах ажиллуулдаг аж ахуйн нэгж, байгууллагуудтай экологийн хариуцлагын гэрээ байгууллаа.

2014 онд ойгоос мод бэлтгэх эрх авсан аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх ажлыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Байгаль орчны газар хамтран зохион байгуулж байна.

Байгаль хамгаалах намрын сарын аяны хүрээнд ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд байгаль орчныг хамгаалах мэдлэг олгох сургалтыг Байгаль орчны газар, Сүхбаатар сумын Засаг даргын Тамгын газар хамтран 2014 оны 11 сарын 24-28-ны өдрүүдэд зохион байгууллаа.

Найм.Сум орон нутгийн талаар:

1.Баянгол сум:

Улсын Их Хурлын даргын нэрэмжит шатар сонирхогчдын улсын аварга шалгаруулах тэмцээний хүрээнд зохион байгуулагдаж буй сумын шатрын аварга шалгаруулах тэмцээнийг 2014 оны 11 сарын 23-ны өдөр зохион байгууллаа.

Эбола вируст халдвараас урьдчилан сэргийлэх, хамгаалах, бэлэн байдлыг хангах тухай тус сумын Засаг даргын А/251 тоот захирамж гарч хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Тус сумын Эрүүл мэндийн төвөөс “Эрүүл амьдарцгаая” витаминжуулалтын аяныг зохион байгуулж байна. Аяны хүрээнд аж ахуйн нэгж байгууллагуудын дунд хандивын аян зарлаж, хандивт ирсэн бүтээгдэхүүнийг ерөнхий боловсролын сургуулийн суралцагчид, цэцэрлэгийн хүүхдүүд, зорилтот бүлгийн хүүхдүүдэд хүргэхээр ажиллаж байна.

2.Баруунбүрэн сум:

Газрын кадастын мэдээллийн сангийн өгөгдлийг засварлах, геодезийн солбицол, өндөр, тусгагийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх, турших, нэгж талбарын хувийн хэргийг шинэчлэн бүрдүүлэх ажил улсын хэмжээнд явагдаж байгаатай холбогдуулан тус сумын Засаг даргын захирамжаар байгуулагдсан

ажлын хэсэг газар өмчилсөн, газар эзэмшиж, ашигладаг иргэн, аж ахуй нэгжүүдийн 1000 гаруй хувийн хэргийн бүрдэлтийг баяжуулах, шинэчлэн бүрдүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын “Өвөлжилтийн бэлтгэл хангах тухай” 09 тоот албан даалгаврын хүрээнд сумын хэмжээнд өвөлжилтийн бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Энэ онд сумын хэмжээнд 147430 толгой мал буюу хонин толгойд шилжүүлснээр 233649 толгой мал өвөлжихөөр тооцоо гарч байна.

Аймгийн Онцгой байдлын газар, Эрүүл мэндийн газар, тус сумын Засаг даргын Тамгын газар хамтран “Байгаль цаг агаарын аюулт үзэгдлийн хор уршгийг арилгах үеийн сумын Засаг дарга, томилгоот бие бүрэлдэхүүний харилцан ажиллагаа” сэдэвт сургуулилтыг зохион байгууллаа.

3. Жавхлант сум:

Сумын Засаг даргын Тамгын газраас нийт 30 төрийн албан хаагчдыг 10 хэсэг болгон хуваарилан сумын иргэдэд цаг үеийн болон 2014 онд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлуудын тайланг мэдээлж, тэдний санал хүсэлтийг хүлээн авч холбодох байгууллага, албан тушаалтнуудад хүргүүллээ.

Тус сумын Засаг даргын 2014 оны А/100 дугаар захирамжаар 2014 оны 11 сарын 13-14-ний өдрүүдэд сумын Засаг даргын Тамгын газраас төр төсвийн байгууллагуудад зөвлөн туслах багийг ажилууллаа.

Жавхлант сумын Эрүүл мэндийн төвөөс “Элэгний хорт хавдрыг эрт илрүүлэе” уриан дор элэгний В, С вирус илрүүлэх, “Чихрийн шижингийн эсрэг дэлхийн өдөр”-ийг тохиолдуулан цусан дахь глюкозын хэмжээг тодорхойлох, артерын даралтыг хянах арга хэмжээг зохион байгуулж, нийт 70 гаруй иргэдийг хамрууллаа.

4. Зүүнбүрэн сум:

Аймгийн Барселон олимпийн зөвлөлийн хороо, тус сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, ерөнхий боловсролын сургууль хамтран 2014 оны 11 сарын 01-ний өдөр “Хөдөлгөөн эрүүл мэнд” сэдэвт спортын арга хэмжээг зохион байгуулж, нийт 100 гаруй иргэд оролцлоо.

Зүүнбүрэн сумын Засаг даргын Тамгын газраас 2014 оны 11 сарын 19-21-ний өдрүүдэд "Алтан намар-2014" ургацын баяраа хийн, сагсан бөмбөг, гар бөмбөг, бөхийн барилдаан, цагаан идээ болон хүнсний ногооны бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдаа, урлагийн тоглолтуудыг зохион байгууллаа.

Сумын Засаг даргын Тамгын газраас 2014 оны 11 сарын 26-ны өдрийг сумын "Төрийн албан хаагчдын өдөр" болгон тэмдэгллээ. Уг арга хэмжээний үеэр "Хамгийн хариуцлагатай, ёс зүйтэй төрийн албан хаагч"-ыг иргэдийн санал асуулгын дүнгээр тодруулж, "Шилдэг илтгэгч", "Хамгийн IQ өндөртэй албан хаагч", "Шилдэг баг хамт олон", "Миний ажил-Миний гэр" болзолт уралдаан, гар бөмбөг, ширээний теннисийн тэмцээн, зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгууллаа.

5. Ерөө сум:

Тус сумын Засаг даргын Тамгын газар, сум дундын Ойн анги хамтран 2014 оны 11 сарын 06-ны өдөр “Ойн санг гэрээгээр эзэмшигч нөхөрлөл, аж ахуйн нэгжүүдийн нэгдсэн зөвлөгөөн”-ийг зохион байгуулан, зөвлөгөөнд оролцогчдоос 9 заалт бүхий зөвлөмжийг гаргаж, Ерөө суманд үйл ажиллагаа явуулж буй ойн санг гэрээгээр эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагууд дагаж мөрдөхөөр шийдвэрлэлээ.

Ерөө сумын Засаг даргын Тамгын газраас иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх зорилгоор зун зусланд “Нээлттэй хаалганы өдөр”-өөр үйлчилж, өвөл өвөлжөөнд нь “Хүлээж биш, хүрч үйлчилэе” уриан доор өрх бүрт хүрч үйлчилэхээр шийдвэрлэж, 2014 оны 11 сарын 07-ны өдөр тус сумын Хандгайт чиглэлд 2014 оны 11 сарын 20-нд Хүзүүвчийн өвөр, Бага буурагчин, Буйлааст,

Жаргалантын тохой, Хужрын хаяа зэрэг газруудад ажиллаж иргэдэд төрийн үйлчилгээг үзүүлээ.

2014 оны 11 сарын 17-19-ний өдрүүдэд “Ургац-2014” арга хэмжээг “Ачит-Оргил” ХХК, “Доолт” ХХК, “Сонсголон ньу Агро” ХХК, “Ачит буурагчин” ХХК, Залуу тариаланч П.Гантулга, Б.Баярсайхан нар нэгдэж өөрсдийн хандив хөрөнгөөр тус сумын Засаг даргын Тамгын газартай хамтран 2014 оны 11-р сарын 17-ны өдөр зохион байгууллаа.

6.Мандал сум:

Мандал сумын Засаг даргын Тамгын газраас эзэн Чингис хааны мэндэлсэн өдрөөр “Төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг” өргөх ёслолын арга хэмжээг зохион байгуулж 8-н албан хаагч тангараг өргөлөө.

Тайлант сард 16 нас хүрч иргэний үнэмлэхээ шинээр гардан авч буй өсвөр үеийн хүүхэд залууст эх оронч үзлийг төлөвшүүлэх, үндэсний бахархал, омогшлыг бадраах, иргэний үүрэг хариуцлагыг ухамсарлуулах зорилгоор “Иргэний андгай өргөх” ёслолын үйл ажиллагааг зохион байгууллаа.

Сумын Засаг даргын Тамгын газар, Хүүхдийн ордон хамтран “Гэр бүлийн витамин”, “Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн ялгаа”, “Эмийн зөв хэрэглээ” сэдэвт сургалтуудыг хүнсний эрхийн бичиг авдаг өрхийн иргэдэд явууллаа.

Тус сумын Засаг даргын Тамгын газраас төр, төсвийн байгууллага, аж ахуйн нэгжүүдийн нягтлан бодогч нарын дунд “Мэдлэг-2014” тэмцээнийг зохион байгуулж, нийт 29 нягтлан бодогч санхүүч нар оролцсоноос 1 дүгээр байранд “СББ” ХХК-ийн нягтлан бодогч, 2 дугаар байранд санхүүч н.Золжаргал нар шалгарлаа.

7.Шаамар сум:

Тус сумын Засаг даргын Тамгын газар, соёлын төв хамтран нийт ажилтан, албан хаагчдынхаа дунд Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн сургалтыг 7 хоног бүрийн мягмар гарагт зохион байгуулж, мэдлэгийг баталгаажуулах АХА танин мэдэхүйн тэмцээн, мэтгэлцээнийг зохион байгуулж байна.

Хүйтний улирал эхэлж байгаатай холбогдуулан сумын иргэдийг нүүрсээр хангах зорилгоор тус сумын Засаг даргын Тамгын газраас Түшиг сумын Улаан Овоогийн нүүрсний уурхайтай гэрээ байгуулллаа. Тус уурхайгаас нүүрс авахаар сумын нийт 3 багийн 100 гаруй өрх захиалгаа өгөөд байна.

Тайлант сард тус сумын Засаг даргын Тамгын газраас Ойн тухай хуулийн хэрэгжилтэнд 5 удаагийн хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, 1 зөрчил илрүүлэн 119 ширхэг нарсан шургаагийг хураан авч 1.650 мянган төгрөгийн нөхөн төлбөр тавьж цагдаагийн байгууллагад шилжүүлээ.

8.Сант сум:

Эбола вируст халдвараас урьдчилан сэргийлэх, хамгаалах, бэлэн байдлыг хангах тухай аймгийн Засаг даргын 2014 оны А/413 тоот захирамж, сумын Засаг даргын 2014 оны А/75 тоот захирамжийн хэрэгжилтийг хангаж, тус сумын Засаг даргын Тамгын газар, эрүүл мэндийн төв хамтран Эбола вируст халдвараас урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж байна.

Шүүхийн шинэтгэлийн хүрээнд хийгдэж байгаа үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг иргэд, олон нийтэд хүргэх, сурталчилан таниулах, иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор сум дундын 22 дугаар шүүхээс “Шүүх иргэн таныг сонсож байна” сэдэвт сургалтыг сумын аж ахуйн нэгж, албан байгууллагын ажилчид, иргэдэд зохион байгуулж, санал асуулга авч 375 иргэн хамрагдлаа.

Аймгийн Хөдөлмөрийн хэлтэс, сумын Засаг даргын Тамгын газар хамтран ойн цэвэрлэгээ нийтийг хамарсан ажлыг зохион байгуулж, Хушаат 2-р багийн

Мухар бүдүүний 4 га талбайд ойн цэвэрлэгээ хийж, 10 иргэнийг түр ажлын байраар хангаж, 1800.0 мянган төгрөгийг олголоо.

9.Сайхан сум:

“ЭРДЭНЭ” ТВ-ээс зохион байгуулсан “Хишиг-Өдөр” нэвтрүүлэгт сум дундын цагдаагийн хэсэг, сумын Засаг даргын Тамгын газрын албан хаагчид оролцон, ажил, мэргэжлээ сольж ажиллан, нэг нэгнийхээ ажил мэргэжлийн онцлогтой танилцлаа.

Дэлхийн зөн олон улсын байгууллагаас жил бүр уламжлал болгон зохиогддог “Зөнгийн одод” урлагийн наадамд 5 төрөлд нийт 300 гаруй сурагчид оролцож шилдэг 7 ноймрыг 1-р шатанд нь шалгарууллаа.

2014 оны 11-р сарын 14-ны өдөр тус сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчид Номгон тосгонд “Нээлттэй хаалга”-ны өдөрлөг арга хэмжээг зохион байгууллаа.

10.Сүхбаатар сум:

2014 оны 10 сарын 30-ны өдөр гал түймэрт өртсөн Ганзамын 7 дугаар багийн Баамын ногоон барилгад амьдарч байсан 15 өрхийн 2 сартайгаас 14 хүртэлх насны 12 хүүхдийг хүйтний улирал эхэлж байгаатай холбогдуулан Сүхбаатар суманд хүүхдийн хувцасний худалдаа эрхэлдэг дэлгүүрүүдийн эзэд иж бүрэн хувцаслалаа. Мөн Сүхбаатар сумын Засаг дарга өөрийн нөөцөөс 15 өрхөд тус бүрт нь 200.0 мянган төгрөгийн буцалтгүй тусламж үзүүллээ.

Тус сумын хэмжээнд дотоодын их дээд сургуульд суралцдаг оюутнуудаас аймгийн Засаг даргын нэрэмжит урамшуулалд хамрагдах оюутнуудын талаар мэдээллийг баг бүрт хүргүүлэн шалгаруулах ажлыг зохион байгуулж байна.

Сүхбаатар сумын хүүхдийн байгууллагуудын хоол хүнсний аюулгүй байдалд хяналт тавих орон тооны бус хяналтын зөвлөл нь ерөнхий боловсролын 7 сургууль, 6 цэцэрлэг, дотуур байранд хяналт, шалгалт явуулан зөрчил илэрсэн 1, 3, 7-р цэцэрлэг, 3, 5, 6-р сургуульд 60.0-150.0 мянган төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч зөрчил дутагдлыг арилгуулах хугацаатай үүрэг албан шаардлага хүргүүллээ.

хот тохижилтын газар нь 2014 оны 10 сарын 25-аас 2014 оны 11 сарын 25-ыг хүртэл үндсэн жолооч 5, ачигч 8, зам талбайн үйлчлэгч 6, сахиул 1 захиргаа аж 200.0 мянган төгрөг, гэрээт ажилчид 3 мянган төгрөг, хуралт явуулагчид 30 мянган төгрөг, хуралт явуулагчид 30 мянган төгрөг, 11-р сард 262 рейсээр 1100 тн хог хаягдлыг зөөн хаявчлах ажлыг гүйцэтгэж байна.

2014 оны 11-р сарын 18-нд тус сумын ерөнхий боловсролын 4-р сургуулийн “Амьдрах чадварт суралцах цаг” хичээлийн сэдвийн хүрээнд 5-р ангийн сурагчидтай хамтран ажиллаж, хүүхдүүдийн санаачлагаар Партизаны талбайн цас цэвэрлэх ажилд туслуулан ажилаллаа.

11.Хушаат сум:

Сумын Засаг даргын А/155 тоот захирамжийн хэрэгжилтийг хангаж тус сумын Засаг даргын Тамгын газраас 2014 оны 10 сарын 29-өөс 1 сарын хугацаанд сумын эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаа, үйлчилгээтэй холбоотой иргэдээс санал асуулга авч дүгнэлт гарган, зөвлөн туслах үйл ажиллагааг явуулж байна.

“Архи, тамхигүй сум” аяны хүрээнд зохион байгуулагдаж буй “Архи, тамхигүй хамт олон” уралдааны хүрээнд аймгийн “Сэлэнгэ амьдрах сайхан” төрийн бус байгууллага, “Ариусахуй” АА-ийн бүлэгтэй хамтран “Архины хор хөнөөл” сургалтыг явуулж 18 иргэнийг хамрууллаа. Цаашид архинаас татгалзаад байгаа иргэдээ дэмжих зорилгоор сумандаа “АА”-ийн бүлэг байгуулахаар ажиллаж байна.

“Эзэнтэй Монгол” хөтөлбөрийн хүрээнд нийтийг хамарсан ажлаар “Цэвэр ой” төслийг хэрэгжүүлж, ажилгүй 10 иргэнийг ойн цэвэрлэгээ хийлгэн түр ажлын байраар ханган 1800,0 мянган төгрөгийн цалин хөлс олголоо.

12.Хүдэр сум:

Тус суманд улсын төсвийн 2.9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар баригдсан төмөр бетонон гүүрний нээлтийг 2014 оны 10 сарын 25-ны өдөр зохион байгуулж, УИХ-ын гишүүн С.Баярцогт, аймгийн засаг даргын орлогч Н.Батдорж, сумын Засаг дарга Б.Наранцэцэг болон иргэдийн төлөөлөл оролцлоо.

Тус сумын Засаг даргын Тамгын газар, “Хувь хүний хөгжлийн хөрөнгө” төрийн бус байгууллагатай хамтран “Үйлчлэн манлайлах уу”, “Мөрөөдлийн хөтөч”, “Багш нарын ёс зүй, зан хандлага”, “Орон нутгийн хөгжилд иргэдийн оролцоо” сэдвүүдээр 2 хоногийн сургалтыг зохион байгууллаа. Тус сургалтанд давхардсан тоогоор 465 иргэн, ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчид хамрагдлаа.

Тус сумын Засаг даргын Тамгын газар, Цагдаагийн алба, эрүүл мэндийн төв хамтран “Аз жаргалтай амьдралын эхлэл” сэдэвт нээлттэй хэлэлцүүлэгийг амжилттай зохион байгууллаа.

Орон нутагт хуш модны самарыг ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтай ашиглаж буй аж ахуй нэгж иргэдээс 371750 мянган төгрөгийн хураамж авч, орон нутгийн төсөвт төвлөрүүллээ.

13.Орхонтуул сум:

Тус сумын Засаг даргын Тамгын газраас сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2014 оны 38 тоот тогтоолоор батлагдсан “Архигүй Орхонтуулчууд” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж “Архигүй эрүүл зан үйлийг төлөвшүүлье” нэг сарын аянг сумын Засаг даргын 2014 оны А\113 тоот захирамжаар 10 сарын 20-оос 11 сарын 19-ний өдрүүдэд зохион байгууллаа.

Сумын “Ургацын баяр-2014” арга хэмжээг 2014 оны 11 сарын 05-ны өдөр зохион байгуулж, “Нэгж га талбайгаас хамгийн өндөр ургац хураан авсан иргэн, аж ахуйн нэгж”, “Хамгийн их хүнсний ногоо тариалсан өрхийн аж ахуйтан”, “Хамгийн их хадлан авсан хадланч”, “2014 оны Тэргүүний механикжуулагч” 5 номинаци шалгаруулж, шагнаж урамшууллаа.

2014 оны эхэнд сумын дүнгээр тэмээ 363, адуу 11693, үхэр 14573, хонь 89510, ямаа 64680 бүгд 180819 толгой мал тоологдосноос нийт малын 46,3 хувийг буюу 83701 хээлтэгч мал эзэлж байна. 2014 онд оны эхний малын 0,4 буюу 768 толгой мал зүй бусаар хорогдосноос тэмээ 3, адуу 68, үхэр 71, хонь 326 ямаа 300 толгой хорогдсон байна. Оны эхний төллөх 83701 хээлтэгчийн 95.0 хувь буюу 79563 толгой хээлтэгч мал төллөж гарсан төлийн 99,5 хувь нь бойжиж байна.

Оны эхний 11 сарын байдлаар тус сумын малчид хонины ноос 100.5 тонн, ямааны ноолуур 19.4 тонныг үйлдвэрлэн зах зээлд болон дотоодын үндэсний үйлдвэрт тушаагаад байна.

14.Орхон сум:

Аймгаас 2014 оныг “Ээлтэй орчин, их бүтээн байгуулалтын жил” зарласантай холбогдуулан сумын Засаг даргын 2014 оны Б/15 тоот захирамжаар байгууллага сурталчлах 14 хоногийн аяныг 2014 оны 11 сарын 10-23-ны хооронд тус сумын Засаг даргын Тамгын газар, Бэлэндалай багийн нутаг дэвсгэр болох Мангиртад байрлах айл өрхүүдтэй хамтран зохион байгууллаа. Тус арга хэмжээний хүрээнд Шийр, 42-р зөрлөг, Хар нүдэн, Мангирт, сумын төвийн айл өрхүүдэд хууль сурталчлах, сум хөгжүүлэх сангийн зээл, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын ажлын талаар мэдээлэл хүргэж, танин мэдэхүйн АХА тэмцээн, 1 мин 10000 төгрөг, Тата-Тунга тэмцээнүүдийг зохион байгуулж, Мангиртын ард иргэдтэй хамтарсан урлагийн тоглолтыг бэлтгэн иргэдэд хүргэлээ.

Тус сумын Засаг даргын 2014 оны А/144 тоот захирамжийн дагуу Орхон хонины зохиомол хээлтүүлгийн ажлыг 2014 оны 10 сарын 20-оос 11 сарын 04 хүртэлх хугацаанд Бэлэндалай багийн нутаг дэвсгэр болох Агьтын хошуунд хийж, Орхон хонийг үржүүлдэг 3 аж ахуй нэгж, 2 малчны 811 толгой Орхон хонь хамруулахаар төлөвлөснөөс 622 толгой хонийг хамрууллаа. Хээлтүүлгийн ажлын

гүйцэтгэл 76,7 хувьтай байна. Аймгийн Засаг даргын 2014 оны А/163 тоот захирамжийн хэрэгжилтийг ханган 350 үхрийг ангилалтанд хамруулахаар төлөвлөснөөс 16 өрхийн 350 үхрийг хамруулж, ажлын гүйцэтгэл 100 хувьтай байна.

Бруцеллёз, сүрьеэ өвчнөөр тайван сүрэгтэнг зарлах тухай журмын шалгуур үзүүлэлтийн дагуу тус сумын Бэлэндалай багийн 4 малчин өрхийг “Мэнд сүрэгтэн”-ээр тодорхойллоо.

15.Цагааннуур сум:

Тус сой үй Цагаан аадааи 2014 ийү А/119 оийò цабөдәи аийн хэрэгжилтийг хангаж, “Өвөл цагийн соёл хүмүүжлийн ажлыг зохион байгуулах нь” сэдэвт ийүөддөүе дүеүөөззёæеацй өеий ааеэбөөлаа.

2014 ийү 11 азыуд нәдүй 13 ия Оаөей өд, иеэе еей цө аө өеей 3 өаөд зөвлөлөөс “Нийгмийн түншлэл-бидний зорилго” сэдэвт сургалтыг бүсийн хэмжээнд цй өеий ааеэбөөеәә. Нодәәөдәи а Озө еә, Цзй азый Оаәаи оод ний үй өдәүд өаи дәәлаа.

2014 оны 11 нәдүй 24-25-ийү өдззәүя тус сумын Оаөей өдөей ар өеәе ааеәәе үдззө аоөей 3 өаөд нәеәәд оийийийн өнәеей 2 ааеэбөөеәәә Оаөей өдөей дөоөү, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль бөөөей дүдүæөдөей өаеәәд дүй аөд, шалгалт цй өеий ааеэбөөәи, цө аө өи æ дзәззөеү.

2014 оны 12 сарын 03 өдрийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах өдөр болгон зарласанөае оий өаи ааөбөәи 2014 оны 11 сарын 25-ны өдөр тус сумын Засаг даргын Тамгын газар, эрүүл мэндийн төв, ерөнхий боловсролын сургууль, ахмадын хороо, эмэгтэйчүүдийн зөвлөл, эмийн сангууд хамтран хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн аой а нээлттэй хэлэлцүүлэг, витаминжуулалтын аяныг зохион байгууләә.

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР